

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Гамшгаас хамгаалах тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай хуулийн төслийн тухай

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр баталсан. Тус хуульд 2020-2024 оны хооронд нэмэлт, өөрчлөлт (хуульд нэмэлт оруулах тухай хууль-3, хуульд өөрчлөлт оруулах тухай хууль-3, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль-5, хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хууль-1) оруулж, нийт 163 хэм хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын өөрчлөлт, практикт илэрч буй хуулийн хийдэл, зөрчлөөс шалтгаалан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.5.2-т “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн идэвхтэй оролцоог хангана” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын Зорилго 7-д “гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх” гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4.14-т “Гамшгийн шуурхай удирдлага, зохион байгуулалтыг оновчтой болгож, гамшгийн улмаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, нийгэм, эдийн засагт учирч болзошгүй хүндрэлийг шийдвэрлэх эрх зүйн орчныг сайжруулна” гэсэн тодорхой зорилтууд тусгагдсан.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Сүүлийн арван жилд Монгол Улсад нийт 50,215 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдож, 4,491 хүн амь насаа алдаж, 991,194 хүн өвчилж, 11.5 сая толгой мал хорогдсон байна. Ус, цаг агаарын гаралтай аюулт үзэгдлийн тоо 2016 онтой харьцуулахад 2025 онд 2.4 дахин нэмэгдсэн нь гамшгаас үйл ажиллагаанд шинэ сорилт үүсгэж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2025 онд гүйцэтгэсэн “Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”-д дараах дутагдал, зөрчлийг тодорхойлсон.

Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д “гамшиг”-ийг “эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрах” гэж тодорхойлсон нь хэмжигдэхүйц шалгуур биш тул гамшгийг тодорхойлох шийдвэр субъектив болж, практикт маргаан дагуулдаг.

ГХтХ-ийн 4.1.4-д “гамшгийн эрсдэл”-ийг зөвхөн “хохирлын магадлал” гэж тодорхойлсон нь UNDRR болон Сендайн үйл ажиллагааны хүрээнд хэрэглэдэг олон хүчин зүйлт тооцооны аргачлал (аюул, өртөх байдал, эмзэг байдал, чадавх)-тай нийцэхгүйгээс гамшгийн эрсдэлийн үнэлгээний аргачлал нэгдмэл бус байна.

ГХтХ-ийн 4.1.6-д “эмзэг байдал”-ыг “аюулт үзэгдэл, осолд өртөгдөх зэрэг” гэж тодорхойлсон нь олон улсын стандартад ялгаатай хоёр ойлголт болох “өртөх байдал” (exposure)-тай адилтгасан байгаа нь үнэлгээний аргачлалд алдаа гаргах нөхцөл болдог.

ГХтХ-ийн 23.1-д “Засгийн газрын гишүүн чиглүүлж, байгууллагын дарга удирдан зохион байгуулж” гэж заасан нь Засгийн газрын бодлого боловсруулах чиг үүрэг тодорхойгүй байснаас байгууллагуудын бүрэн эрхийн хооронд давхардал үүссэн. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын 21 дэх илтгэлд “гамшгийн хариу арга хэмжээний удирдлага, зохион байгуулалтад цөөнгүй байгууллага, албан тушаалтан оролцдог, шийдвэр гаргах шат дамжлага олон бөгөөд байгууллагуудын бүрэн эрх, чиг үүрэг ойлгомжгүй” гэж тодорхойлсон байна. Коронавирусийн цар тахлын үед Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын онцгой комиссын зохицуулалт хэд хэдэн удаа өөрчлөгдсөн нь удирдлагын түвшинд давхардал, хийдэл үүсэх шалтгаан болсон.

ГХтХ-ийн 10.3-т “өдөр тутмын бэлэн байдал”-ын үед авах арга хэмжээтэй 10.4-т заасан “өндөржүүлсэн бэлэн байдал”-ын үеийн арга хэмжээнүүд агуулгын хувьд давхардаж байгаа бөгөөд “өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ бараг ижил байдлаар хуульчилсан” гэж дүгнэсэн. Мөн ХЗҮХ-ийн тайланд “сүүлийн жилүүдэд өндөржүүлсэн бэлэн байдлыг ГХтХ-д заасан үндэслэл тогтоогдоогүй байхад зарлаж байгаа нь иргэдэд өндөржүүлсэн бэлэн байдал зарласан ч хэвийн амьдралын горимоор амьдарч болохоор буюу сэтгэл зүйн хувьд үл тоох хэв шинжийг бий болгож байна.” гэж дурдсан.

ГХтХ-ийн 4.1.13-д “нэмэлт хүч хэрэгслийг татан оролцуулах, шаардлагатай барилга байгууламж, газрыг ашиглах” гэж тодорхойлсон нь иргэн, аж ахуйн нэгжийн биет эд хөрөнгийг дайчлах эрх зүйн үндэслэл тодорхойгүй байсан. 2023 оны үерийн үед иргэдийн хөрөнгийг дайчлан авсан боловч нөхөн олгох процесс ойлгомжгүй болж, иргэдийн гомдол гарсан тухай тайланд тодорхой дурдсан байна.

ГХтХ-ийн 51.2-т аймаг, сум, нийслэл, дүүрэг тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар заасан боловч 2026 оны байдлаар орон нутгууд дунджаар төсвийнхөө 1.0-ээс доошгүй хувийг бус ойролцоогоор 0.5 хувийг тусган хэрэгжүүлж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Хоёр. Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Зорилго, бүтэц

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн шаардлагыг хангасан, 7 зүйлтэй байна. Гамшгаас хамгаалах тухай хуулийн нийт 515 зохицуулалтаас 183 зохицуулалтад, өөрөөр хэлбэл 36 хувьд өөрчлөлт оруулсан. Үүнд, шинээр нэмсэн 52, өөрчлөн найруулсан 43, нэмэлт оруулсан 22, хассан 14, өөрчилсөн 40, хүчингүй болгосон 12 зохицуулалт тус тус төсөлд орсон.

2.2. Хуулийн төслийн гол агуулга

Нэгдүгээрт, Нэр томьёоны тодорхойлолтыг олон улсын стандартад нийцүүлж, хуулийн 13 нэр томьёоны тодорхойлолтыг өөрчлөн найруулж, 3 шинэ нэр томьёог нэмсэн.

Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.1-д “гамшиг”-ын тодорхойлолтоос “эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан” гэснийг “гамшигтай тэмцэх чадавхаас давсан хохирол учирч, нийгмийн хэвийн үйл ажиллагаа алдагдах” болгосон. “Гамшигтай тэмцэх чадавх” гэсэн шинэ 4.1.27-ын тодорхойлолтоор тодотгосон бөгөөд НҮБ-ын UNDRR-ийн стандарттай нийцсэн.

ГХтХ-ийн 4.1.4-т “гамшгийн эрсдэл”-ийн тодорхойлолтыг “аюул, өртөх байдал, эмзэг байдал болон гамшигтай тэмцэх чадавхын харилцан хамаарлаар тодорхойлогдох хохирлын магадлал” болгосон.

ГХтХ-ийн 4.1.6-д “эмзэг байдал”-ыг “аюулыг тэсвэрлэх байдал” гэж тодорхойлсноор “өртөх байдал” (exposure)-тай адилтгасан байдлыг арилгаж, нийгмийн болон физик эмзэг байдлыг хоёуланг хамруулах болсон.

ГХтХ-ийн 4.1.3-т “осол”-ын тодорхойлолтод “технологийн горим зөрчигдсөнөөс” гэснийг “хүний буруутай болон санамсаргүй үйлдлээс” гэж өөрчилснөөр хүний буруутай үйлдлийн улмаас үүссэн олон төрлийн ослыг хамруулж, “объектын гал түймэр”-ийг тусгайлан нэмсэн.

ГХтХ-ийн 4.1.13-д “хүч хэрэгсэл дайчлан гаргах”-ын тодорхойлолтод “иргэн, хуулийн этгээдийг татан оролцуулах, тэдгээрийн эд хөрөнгө, газрыг ашиглах” гэж нарийвчилсан. Иргэний хуулийн 84 дүгээр зүйлийн дагуу “эд хөрөнгө” нь биет эд юмс буюу тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийг хамардаг тул дайчилгааны хамрах хүрээг тодорхой болгож, хуулийн төслийн 19.4, 19.5-аар нөхөн олговрын зохицуулалтыг нэмснээр 2023 оны үерийн үеэр үүссэн нөхөн олговрын хүндрэлийг цаашид арилгах эрх зүйн үндэс бүрдсэн.

ГХтХ-ийн 4.1.19-д заасан “гамшгийн онцгой нөхцөл байдал”-ын тодорхойлолтод “хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдах” гэсэн нэмэлт шалгуур тавьсан нь хэт өндөр босго тогтоосон байсан. Тухайлбал, хохирол ноцтой байсан ч нийгмийн хэвийн үйл ажиллагаа алдагдаагүй гэж дүгнэгдвэл “гамшгийн онцгой нөхцөл байдал” зарлах үндэслэл хангагдахгүй болдог байсан нь хариу арга хэмжээ авахад саад болох эрсдэлтэй. Мөн одоогийн тодорхойлолтод “ноцтой хохирол” гэж шалгуур тавьсан нь субъектив бөгөөд хэмжих боломжгүй. Хохирол ноцтой эсэхийг хэн, ямар шалгуураар дүгнэх нь тодорхойгүй байснаас онцгой нөхцөл байдал зарлах шийдвэрт эргэлзээ, хоцрогдол

гардаг байсан. Хуулийн төсөлд “хохирол учруулсан буюу учруулахуйц” гэж хоёр үе шатыг хамруулсан. Хохирол аль хэдийн учирсан нөхцөлд зарлахаас гадна учруулах магадлал өндөр байгаа үед урьдчилан зарлах боломжийг хуульчилснаар эрт сэрэмжлүүлэх, нүүлгэн шилжүүлэх, хүч, хэрэгсэл байрлуулах зэрэг урьдчилсан арга хэмжээ авах зэрэг ач холбогдолтой. “Хүн-нийгэм-эдийн засгийн тогтвортой байдал алдагдах” шалгуурыг хасаж “эд хөрөнгө, барилга байгууламж”-ийг нэмснээр хамрах хүрээ тодорхой болж, цар хүрээ багатай осол, аюулт үзэгдлийг ч “гамшгийн онцгой нөхцөл байдал”-д хамруулах эсэхийг объектив шалгуураар тодорхойлох боломж нэмэгдсэн.

Хоёрдугаарт, бэлэн байдлын зэргийг хоёр шатлалтай болгосон. Тухайлбал, “Бүх нийтийн бэлэн байдал”-ын зэргийг хасаж, “байнгын болон өндөржүүлсэн” гэсэн хоёр шатлалтай болгосон. “Байнгын бэлэн байдал” гэсэн нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага аливаа онцгой нөхцөл байдлын үед нэгдсэн удирдлага, төлөвлөлттэй байх зорилгоор бэлэн байдлын түвшинг илэрхийлэх нэр томьёо ижил байх жишигт нийцүүлсэн.

Гуравдугаарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хамрах хүрээг хуулийн этгээдийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулж шинэчилж, гамшгаас хамгаалах хяналтын болон гамшгаас хамгаалах сургалтын зохион байгуулалтыг тодорхой болгосон.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тогтолцоог шинэчилсэн. Тухайлбал, ГХтХ-ийн 8.1-д “хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна” гэснийг “улсын болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, гамшгаас хамгаалах алба, аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд боловсруулж хэрэгжүүлнэ” гэж өөрчилсөн. Одоогийн хуульд зөвхөн төлөвлөгөөтэй байх үүргийг заасан боловч тухайн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүргийг тусгаагүй байсан тул зарим байгууллага хэлбэрийн төдий төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлэхгүй байх нөхцөл үүсэж байсан. Одоогийн 8.1-д “хуулийн этгээд” гэснийг шинэ найруулгад “аж ахуйн нэгж, байгууллага” гэж задалсан нь аж ахуйн нэгж (хувийн хэвшил) болон байгууллага (төрийн бус, олон нийтийн) гэсэн ялгааг тодорхой болгосон. Мөн шинээр нэмж буй 8.5-д бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч болон цахим хэлбэрийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид тохирсон зохицуулалтыг тус тус тусгасан.

Гамшгаас хамгаалах сургалт, хяналтын тогтолцооны эрх зүйн үндэслэлийг тогтоосон. ГХтХ-ийн 12.1-т гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх байгууллагыг “онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэж тодорхойлсноор гамшгаас хамгаалах хяналтын зохицуулалтын хийдлийг арилгаж, хяналтыг эрх хэмжээ, харьяаллын хувьд тодорхой болгосон. Мөн Галын аюулгүй байдлын тухай хуульд гал түймрийн хяналтын улсын байцаагчийн бүрэн эрх, хяналтын цар хүрээг хуульчилсан ч гамшгаас хамгаалах хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг ГХтХ-д тусгаагүй байсныг 12.4-т нэмсэн зохицуулалтаар хийдлийг арилгасан.

Дөрөвдүгээрт, гамшгаас хамгаалах сургалт, мэдээлэл, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийт, сайн дурынхны оролцоог

нэмэгдүүлэх, эдгээртэй холбоотой зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

ГХТХ-ийн 13.6-13.9-ийг шинээр нэмж гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын дадлага сургуулийг тогтмол зохион байгуулах зохицуулалтыг хуульчилсан. ГХТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд, 2020-2024 онд иж бүрэн сургууль 91 удаа, команд штабын сургууль 164 удаа зохион байгуулсан боловч сургалтыг хариуцан зохион байгуулах субъект тодорхойгүй, эрх зүйн зохицуулалт практикт хэрэгжихгүй байх, хууль хоорондын уялдаа холбоо алдагдах эрсдэлтэй учир гамшгаас хамгаалах сургалттай холбоотой зохицуулалтуудыг боловсронгуй болгох шаардлагатай гэж дурдсан.

Тавдугаарт, гамшгийн үеийн удирдлагын тогтолцооны давхардал, хийдлийг арилгасан. Тухайлбал, Хуулийн 23.1-д Засгийн газрын “бодлого, стратегиар хангах” чиг үүргийг нэмж, Засгийн газар (бодлого, стратеги), Засгийн газрын гишүүн (чиглүүлэх), ОБЕГ-ын дарга (мэргэжлийн удирдлага) гэсэн гурван шатлалт тодорхой тогтолцоог оруулсан.

ГХТХ-ийн 22.3-т Улсын онцгой комиссын бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газраар батлуулахаар тогтоож удирдлагын нэгдмэл байдлыг хангасан.

Хуулийн 27¹.1.4-д “гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар” гэснийг “холбогдох асуудлаар” гэж өөрчилснөөр УОК гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохицуулалт, хариу арга хэмжээтэй холбогдох асуудлаар тогтоол, шийдвэр гаргах бүрэн эрхийг тодорхой болсон.

Зургаадугаарт, гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах харилцаанд хүний эрхийг хязгаарлах, эд хөрөнгийн эрхтэй холбогдох арга хэмжээ үүсэхтэй холбогдуулан хүч хэрэгсэл дайчлах, иргэн, аж ахуйн нэгжийн эд хөрөнгийг гамшгаас хамгаалах зорилгоор ашиглах, түүнтэй холбоотой нөхөн олговрын зохицуулалтыг боловсронгуй болгож, иргэн, хуулийн этгээдийн өмчийн эрхийг хамгаалах эрх зүйн баталгааг сайжруулсан.

Долоодугаарт, Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн нийгмийн баталгааг сайжруулсан. Тухайлбал, ГХТХ-ийн 50.9-д алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг 30 хувиас 40 хувь болгон нэмэгдүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухай алба хаагчийн сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгох шийдвэртэй уялдуулсан ба ОББ-ын алба хаагчийн цалин нэмэгдлийг дээшлүүлэх нь мэргэшсэн ажиллах хүчнийг тогтвортой байлгах ач холбогдлыг сайжруулсан.

ГХТХ-ийн 45.4-т мэргэжлийн туршлагын шаардлагыг зөвхөн байгууллагын даргад бус тэргүүн дэд болон дэд дарга нарт мөн адил хамруулсан нь удирдах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, шаардлагын тасралтгүй байдлыг хангана.

ГХТХ-ийн 50.15-50.18-д гадаадад суралцаж буй алба хаагчийн зарим зардлыг төр хариуцах, жил бүрийн эрүүл мэндийн үзлэгийг улсын төсвөөс санхүүжүүлэх,

бэлэн байдлын зэрэгт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчид олгох хоол, хүнсний зардлын хэмжээ тогтоох эрхийг тус тус тусгасан.

Наймдугаарт, Гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Тухайлбал, ГХтХ-ийн 42.10-т “онцгой байдлын байгууллагын салбар, нэгжгүй сумын Засаг даргын тамгын газарт онцгой байдлын байгууллагын нэг алба хаагчийг томилж ажиллуулна” гэж шинээр нэмсэн. Сумдад гамшгаас хамгаалах үйл ажиллагаа хариуцсан мэргэжлийн алба хаагч томилж ажиллуулахаар тусгасан нь ОББ-ын салбар нэгжгүй 252 суманд гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад тэгш, хүртээмжтэй хүргэх боломж бүрдсэн.

Томоохон аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан, улсын онц чухал болон стратегийн зориулалттай төрийн өмчит үйлдвэрийн газарт гэрээт нэгж болон байцаагчийг ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн

Есдүгээрт, гамшгаас хамгаалах санхүүжилтийн тогтолцоог шинэчилсэн. Тухайлбал, ГХтХ-д 51.5-51.11-ийн зохицуулалтыг шинээр нэмж аймаг, сум, нийслэл, дүүрэгт “Гамшгийн эрсдэлийг бууруулах сан” байгуулах тогтолцоог бүрдүүлсэн. Энэ нь 51.2-т заасан жилийн 1.0 хувийн хөрөнгийг дараа жилд шилжүүлэн хуримтлуулах, олон улсын зээл, буцалтгүй тусламж, хандивыг нэгтгэн зарцуулах боломж бүрдүүлснээр гамшгаас урьдчилан сэргийлэх тогтвортой санхүүжилтийн эх үүсвэр болсон.

ГХтХ-ийн 51.10-51.11-д гамшиг, ослын шинжгүй дуудлагаар ажилласан зардлыг дуудлага өгсөн этгээд хариуцахаар хуульчилсан нь төсвийн үргүй зардлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа гарах үр дагавар

Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн дараах үр дагавар гарна. Үүнд:

Нэгдүгээрт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 36 хувьд нэмэлт, өөрчлөлт орох ба нэр томьёоны тодорхойлолт нь НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар (UNDRR)-ын болон олон улсын стандарттай нийцэж, хуулийн нэгдмэл байдал, хэрэглээний тогтвортой байдал хангагдана.

Хоёрдугаарт, Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, бүх оролцогч талуудын чиг үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ оновчтой, тодорхой болно.

Гуравдугаар, гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцооны давхардал, хийдэл арилж, гурван шатлалын удирдлагын зааг ялгаа тодорхой болж, гамшгийн үеийн шуурхай удирдлага зохицуулалт сайжирч, гамшгийн улмаас нийгэм, эдийн засагт учрах хохирол буурна.

Дөрөвдүгээрт, Онцгой байдлын байгууллагын салбар нэгжгүй 252 суманд онцгой байдлын нэг алба хаагч томилогдсоноор гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээ иргэдэд тэгш хүрч, орон нутгийн хариу арга хэмжээний чадавх, хүн амын гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвар нэмэгдэнэ.

Тавдугаарт, орон нутгийн түвшинд “Гамшгийн эрсдэлийг бууруулах сан” байгуулагдсанаар гамшгаас урьдчилан сэргийлэх тогтвортой санхүүжилт бий болж, улсын төсөвт ирэх ачаалал буурна.

Зургаадугаарт, төр хувийн хэвшлийн түншлэл, салбар дундын хамтын ажиллагаа сайжирч, иргэд, олон нийтийн оролцоо нэмэгдэж гамшгаас хамгаалах бэлтгэл бэлэн байдал дээшилнэ.

Долоодугаарт, гамшиг, ослын шинжгүй, хуурамч дуудлагаар үүрэг гүйцэтгэсэн зардлын хариуцлагын зохицуулалт бий болсноор төсвийн үргүй зардал буурч, гамшгаас хамгаалах байгууллагын хүч нөөцийг үндсэн чиг үүрэгт чиглүүлэх боломж нэмэгдэнэ.

Наймдугаарт, гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг ялгаварлахгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх эрх зүйн орчин бүрдэж, олон улсын хүний эрхийн стандартад нийцсэн, бүх нийтийн оролцоонд тулгуурласан гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавх бүхий гамшгаас хамгаалах тогтолцоо төлөвших эрх зүйн үндэс бүрдэнэ.

Дөрөв. Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах тухай

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.3, 19.1 дүгээр зүйлд заасан иргэний эрх хамгаалах болон өмчийн эрхийн зохицуулалттай нийцнэ. Олон улсын гэрээний хувьд НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ 2015-2030 баримт бичгийн дөрвөн тэргүүлэх чиглэлтэй нийцэж, НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар (UNDRR)-ийн болон бусад олон улсын стандарттай нийцсэн нэр томъёоны тогтолцоог бий болгосон.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Галын аюулгүй байдлын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслийг тус тус боловсруулсан.